



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 479

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 286 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны ХЭГ/2475 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба (хуучнаар Замын цагдаагийн газар)-ны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламжийг худалдах нээлттэй дуудлагын худалдаанд нэг ч оролцогч ирээгүй тул дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2. Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламжийг худалдах нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тооцож 11,227,248,000.00 (арван нэгэн тэрбум хоёр зуун хорин долоон сая хоёр зуун дөчин найман мянган) төгрөг дээр үнэлгээний ажлын зардал 7,000,000.0 (долоон сая) төгрөг, зар сурталчилгааны зардал 10,752,000.0 (арван сая долоон зуун тавин хоёр мянган) төгрөгийг нэмж 11,245,000,000.00 (арван нэгэн тэрбум хоёр зуун дөчин таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

3. Дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 10 хувь буюу 1,124,500,000.00 (нэг тэрбум нэг зуун хорин дөрвөн сая таван зуун мянган) төгрөгөөр, үнэ өсгөх доод шатлалыг 10,000,000.00 (арван сая) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, нийтэд зарлахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламжийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль, захиргааны актын дагуу зохион байгуулахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000989

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2019 оны 11 дүгээр сарын 19-ны
өдрийн 429 дүгээр тогтоолын хавсралт



**ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
5 БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ ДООД ҮНЭ**

Д/д	Барилга байгууламжийн нэр	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 121 дүгээр тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Бууруулсан үнэ		Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
			Хувиар	Төгрөгөөр	
1	Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламж	12,474,720,000.00	10	1,247,472,000.00	11,227,248,000.00